Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлагдсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын Авлига, мөнгө угаах гэмт хэрэг хянан шийдвэрлэх хэлтэс
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Авлига, мөнгө угаах гэмт хэрэг хянан шийдвэрлэх хэлтсийн дарга, ахлах прокурор	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Авлига, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, хяналт тавих, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, нэгж прокурорын газрыг мэргэжлийн удирдлагаар хангах.

Албан тушаалын зорилт:

1.Авлига, мөнгө угаах гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, нэгж прокурорын газрыг мэргэжлийн удирдлагаар хангах;

2.Авлига, мөнгө угаах гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх;

3.Прокурор, ажилтныг өдөр тутмын удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Хариуцан гүйцэтгэх- Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Авлига, мөнгө угаах гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.	Бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна	Т, Г, Х
	1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийн санал боловсруулж, биелэлтийг хангуулах.	Төлөвлөлтийг оновчтой хийж, биелэлтийг хангуулсан байна.	Г, Х
	1.3.Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийх мэдээлэл, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй харилцах чиглэлээр гаргах санал, дүгнэлт, тайлбарын төслийг боловсруулж, танилцуулах.	Үндэслэл бүхий мэдээлэл, санал, дүгнэлт, тайлбарын төсөл боловсруулсан байна.	Г
	1.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, заавар, мэдээлэл, санал, албан бичигт гаргах санал, тайлбарын төсөл боловсруулах.	Санал, тайлбарын төслийг боловсруулсан байна.	Г, Х
	1.5.Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл газрын даргад танилцуулах.	Үндэслэл бүхий санал танилцуулсан байна.	Г
	1.6.Авлига, мөнгө угаах гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой нэгж прокурорын газар, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаас чиглэл авахаар ирүүлсэн санал, хүсэлтийг судалж танилцуулах.	Санал, хүсэлтийг танилцуулсан байна.	Г, Х
	1.7.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар прокурорын байгууллагаас хүргүүлж буй тайлан, мэдээ, мэдээллийг боловсруулах.	Холбогдох мэдээллийг үндэслэл бүхий боловсруулсан байна.	Г, Х
	1.8.Эрүүгийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулах, хэрэгжилтийг хангуулах.	Санал гаргаж, танилцуулсан байна.	Г, Х

	1.9.Хууль, заавар, журмын хэрэгжилт, шалгалт, судалгааны дүнгийн талаар нэгж прокурорын газар, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад хүргүүлэх чиглэл, зөвлөмж, мэдээллийн төслийг боловсруулах.	Чиглэл, зөвлөмж, мэдээллийн төслийг боловсруулсан байна.	Г, Х
	1.10.Эрүүгийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг дангаараа болон бусад газар, хэлтэстэй хамтран шалгах, судлах ажлыг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох.	Шалгалт, судалгааг хийж, үр дүнг тооцсон байна.	Г, Х
	1.11.Авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр гадаад орны туршлага, хууль хэрэглээний талаар судалж, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх талаар санал боловсруулж танилцуулах.	Санал боловсруулж, танилцуулсан байна.	Г, Х
	1.12.Хэлтсийн чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г
	1.13.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоос өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
	1.14.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Авлига болон мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний төлөвлөгөөнд хариуцсан чиглэлээр тусгагдсан ажил, арга хэмжээг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох.	Ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна.	Г, Х
	2.2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор хариуцсан чиг үүргийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.	Хамтран ажилласан байна.	Г, Х
	2.3.Авлига, мөнгө угаах гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоос гаргасан гомдлын дагуу холбогдох эрүүгийн хэрэг, материалыг хянаж, дээд шатны прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх, прокурорын даалгавар бичиж, биелэлтийг тооцох.	Гомдлыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлүүлсэн байна.	Г, Х

	2.4.Иргэн, хуулийн этгээдээс гаргасан авлига, мөнгө угаах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг танилцуулах, шийдвэрлэх.	Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэсэн байна.	Г, Х
	2.5.Авлига, мөнгө угаах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, түүнд тавих прокурорын хяналтын харьяаллыг тогтоолгох саналтай ирүүлсэн хэрэг, материалыг хуваарилах, харьяаллын саналыг шийдвэрлэх.	Харьяалал тогтоохтой холбоотой хууль, зааврын заалт хангагдсан байна.	Г, Ш
	2.6.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэд хэдэн байгууллагын хамтарсан ажлын хэсэг байгуулах саналыг танилцуулж, шийдвэрлүүлэх.	Саналыг танилцуулсан байна.	Г, Х
	2.7.Прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгуулах саналыг танилцуулж, шийдвэрлүүлэх.	Шийдвэрийг хуульд нийцүүлсэн байна.	Г, Х
	2.8.Авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх чиглэлээр бусад байгууллагатай хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах, шийдвэрийн биелэлтийг тооцох.	Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн биелэлт хангагдсан байна.	Г
	2.9.Нэгж прокурорын газраас ирүүлсэн авлига, мөнгө угаах гэмт хэргийн танилцуулга, хэргийн материалыг хянаж, мөрдөн байцаалтын хугацааг сунгах эсэхийг танилцуулж, шийдвэрлүүлэх.	Саналыг шийдвэрлэсэн байна.	Г, Х
	2.10.Авлига, мөнгө угаах гэмт хэргийг давхар хяналтад авах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх прокурорыг томилох талаар дээд шатны прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх.	Хэлтсийн прокуроруудаас тогтмол танилцаж, шийдвэрлэлтэд хяналт тавьсан байна.	Г
	2.11.Хяналтын ажлын аргачилсан зааварт заасан болон бусад шаардлагатай гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн талаарх мэдээллийг дээд шатны прокурорт танилцуулах, холбогдох арга хэмжээ авах.	Дээд шатны прокурорыг мэдээллээр шуурхай хангасан байна.	Г
	2.12.Авлига, мөнгө угаах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх судалгааг нэгтгэх ажлыг зохион байгуулж, дээд шатны прокурорыг мэдээллээр хангах, нэгж прокурорын газруудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.	Мэдээллээр хангасан байна.	Г

	2.13.Хариуцсан ажлын чиглэлээр нэгж прокурорын газарт өгөх хугацаатай үүрэг даалгаврын төслийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих.	Үүрэг даалгавар хуульд нийцсэн, чиг үүрэгт хамаарахуйц байх ба биелэлтийг тооцсон байна.	Г
	2.14.Авлига, мөнгө угаах гэмт хэргийг давхар хяналтад авах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх прокурорыг томилох талаар дээд шатны прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх.	Хэлтсийн прокуроруудаас тогтмол танилцаж, шийдвэрлэлтэд хяналт тавьсан байна.	Г
	2.15.Давхар хяналтад орсон хэргийн үйл явц, шийдвэрлэлтийн талаар танилцаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, давхар хяналтыг үргэлжлүүлэх, эсхүл зогсоох эсэхийг танилцуулж, шийдвэрлүүлэх.	Мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1. Хэлтсийн прокурор, ажилтнуудын ажил үүргийг хуваарилж, мэргэжлийн удирдлагаар хангах.	Өгсөн үүрэг, даалгавар хэрэгжсэн байна.	Г
	3.2.Хэлтсийн хэмжээнд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Х
	3.3.Хариуцсан ажлын чиглэлээр мэдээ, тайлан гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцох.	Мэдээ, тайланд үнэлэлт дүгнэлт өгч, тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	3.4.Хариуцсан ажлын чиглэлээр мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх арга хэмжээ авах.	Мэдээ, мэдээллийг бэлтгэж, олон нийтэд хүргэсэн байна.	Г, Х
	3.5.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	3.6.Дээд шатны прокурорын томилсноор газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэх.	Газрын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл хангагдсан байна.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	Эрх зүй (0421)		

Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Прокуророор 5-аас доошгүй жил, үүнээс Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, ахлах прокурор, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор, ерөнхий прокурорын орлогчоор 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-газрын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1. Хэлтсийн хяналтын прокурор 2. Газар, хэлтсийн туслах ажилтан 3. Аймаг, нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурор, түүний орлогч, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор 4. Нийслэлийн прокурорын газрын Авлига, мөнгө угаах гэмт хэрэг хянан шийдвэрлэх хэлтсийн дарга, хяналтын прокурор Нийт:4	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага 3.Шүүх 4.Бусад төрийн байгууллага 5.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Дугаар: А/95 УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦАЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр	